

ШИНЭ ТОСГОН ХӨДӨЛГӨӨНИЙ ОЛОН УЛСЫН ШИНЖ ТӨРХ*

Ким Юхйөг

БНСУ дахь шинэ тосгон хөдөлгөөний зорилго нь ядуу зүдүү байдлаас ангижруулахад орших билээ. Ядуу зүдүү байдал нь ужиг өвчний тулам болохын зэрэгцээ элдэв бэрхшээлийн голомт ч болдог. Ядуу зүдүү байдал, өвчин эмгэг, харанхуй бүдүүлэг, дайн-эдгээрийг хүн төрөлхтний дайсан (гачаал) гэж хэлэлцдэг. Эл дөрвөн зүйлийг агуулагч нь ямар ч тохиолдолд бусадтай өрсөлдөөд ялахын тавилангүй. Түүгээр ч үл барам тэр зүйлс хөдөөгийн нийгэмд байваас хөгжлийн тухай санасны хэрэггүй. Улсын тухайд ч дүгнэлт нь адил. Манай улс дэлхийн ямар ч орноос дутахгүй өнө удаан жилийн түүхтэй. Мөн нэгэн үндэстний уламжлалтай. Силла, Когурियो, Пэгчэ буюу гурван улсын үеэс солонгосчууд соёлын гайхамшигт бүтээлээрээ бахархсаар ирэв. Хэдий тийм боловч 5000 жилийн туршид нэг ч удаа тэргүүний орон гэсэн нэр зүүсэнгүй. Түүний шалтгаан нь юусан билээ? Хамгийн том шалтгаан нь ядуу хоосон байдал юм. Тэрхүү ядуу зүдүү байдал нь хэрхэн яагаад тийм удаан үргэлжилдэгсэн билээ? Хөрш зэргэлдээ орших хүчирхэг гүрнүүд (хятад, монгол, орос, япон)-ийн хатуу шалгалт үргэлжилснээс ядуу зүдүү байдлаас ангижрахад бэрхтэй байсныг давтан өгүүлэхийн хэрэггүй.

Ялангуяа дээр үед дайн үүсэх шалтгаан ч юм уу, дайны үр дагавар нь ихэвчлэн эдийн засгийн нөхцөлийг гол агуулгаа болгодог байв. Тиймээс тэр нь ядуу зүдүү байдалд хүргэж ядуу зүдүү байдал нь хөгжлийг саатуулж улмаар нийт хүний үзэн яддаг дээрхи дөрвөн гачаалыг буй болгожээ. Өнөөдөр ч гэсэн байдал хүнд бэрх газарт өлсгөлөн, гуйранчлал, өвчин, зовлон, нийгмийн хэрүүл маргаан тасрахгүй байна. Манай улс ч олон зууны турш ядуу зүдүү байдалтай явж ирсэн нь хүн төрөлхтний дөрвөн их гачаал нүүрлэсний учир юм. Дээрх дөрвөн гачаалын дотроос дайн дажин, өвчин эмгэг, бүдүүлэг харанхуйгаас ангижрах гэдэг хялбар бус аа. Учир нь гадаад хүчнээс болж үүссэн дайныг сул дорой ганц биеэр туулах хэцүү бөгөөд харанхуй бүдүүлэг гэгчийг соён гэгээрүүлэхэд ихээхэн хөрөнгө зардал, урт удаан хугацаа шаардлагатай ба өвчин эмгэгээс ангижрахад хүний биед тэжээллэг хоол хүнс их хэрэгтэй. Харин ядуу зүдүү байдал бол хувь хүмүүсийн сэтгэлийн хүчин чадлаас ихээхэн шалтгаалах талтай.

Манай улс дахь шинэ тосгон хөдөлгөөн нь нэг үгээр хэлэхэд, ядуу зүдүү байдалтай тулалдах арга юм. Амьдрал ахуйдаа арвилан хэмнэлт нэвтрүүлж хуримтлалаа арвижуулж ядуу зүдүү байгаагийнхаа шалтгааныг тал бүрээр бодон олж хөдөлмөрлөн амьдрахын зэрэгцээ, хүч бололцоогоо шавхан ганцаар буюу олуулаа нийлэн чармайн ажилласны үр дүнд хөдөөгийн хүн ам ядуу зүдүү байдлаас ангижирч чадсан болно. Ядуу зүдүү байдлаас ангижирлаа гэдэг маань жаахан нөөцтэй боллоо гэсэн үг бөгөөд энд нөөц гэдэг нь худалдан авах чадварыг хэлж байна. Худалдан авах чадвар дээшилснээр амьдралын хэрэглээний байдал өөрчлөгдөж эхэлнэ. Өдөр тутмын амьдралд хоолны

* Ким Юхйөг «Шинэ тосгон хөдөлгөөн ба гэр загварт хот». Сеул, 1991, номын 157—197 дахь талаас товчлон авав.

Ким Юхйөг —Данкугийн их сургуулийн (БНСУ) Орон нутгийн хөгжлийн хүрээлэнгийн захирал, доктор, профессор.

зүйлийг сонгохдоо хэмжээ гэхээсээ чанарыг голлох ба төрлөөс гадна амт сайтайг шилэх болно. Хоол ундны чанар сайжирч амт дээшлээд ирэхлээр хүмүүсийн биеийн жин ахиж царай зүс ороод эрүүлжээд ирнэ.

Нөгөө талаар эрүүл саруул болноо гэдэг нь эрүүлжүүлэх хөдөлгөөнийг тусад нь өрнүүлэх хэрэгцээгүй болно гэсэн үг. Түүгээр ч үл барам нөөц буй болохлоор түүнийг хүүхдээ сургаж боловсруулахад зарцуулж эхэлнэ. Боловсрол олох бслолцоо боломж гараад ирэхлээр нийгмийн харанхуй бүдүүлэг байдал аяндаа арилж эхэлнэ. Ийнхүү ядуу зүдүү байдлаас ангижирснаар өвчин эмгэг, харанхуй бүдүүлэг байдлаас нэг зэрэг салах нь энэ. Манай улстай адил түүхэн үеийг элээсэн, хөрөнгө зоорь багатай, бага нутагтай, олон хүнтэй бидний зэргийн буюу биднээс дор хөгжилтэй орнуудад шинэ тосгон хөдөлгөөний туршлага олон улсын ач холбогдолтой хэмээн санана.

Монголын хөдөөгийн нийгмийн одоогийн байдал, хөгжлийн зорилтууд

Монголын тухайд хөдөөгийн нийгэм гэдэг ухагдахуун жаахан онцлогтой. Учир нь нүүдэлчдээс бүрдэж байгаад оршино. Аймгийн төв зэрэг нь хотын байдалтай боловч хэмжээгээр бага.

Монголд тосгон гэвэл 4—5 гэрийг хэлэх ба 15 орчим гэр нэг дор бөөгнөрсөн байвал манай нэг мйон болох жишээтэй. Тосгон 20 орчим хүнтэй мйон гэвэл 50—100 хүнээс хэтрэхгүй. Түүнээс гадна жилийн 9 сарыг нь нүүдэллэн амьдрах тул орон нутгийн нийгэм гэдэг ойлголтыг нүүдэлчдийн хөдөөгийн нийгэм гэх нь ч илүү тохиромжтой байж магадгүй.

Ийм байдлаар авч үзэхэд монголын хөдөөгийн нийгмийг хөгжүүлэх зорилтууд нэлээн олон тоонд хүрч болзошгүй.

Нэгдүгээрт, нутаг уудамтай боловч хүн ам хэт цөөн.

Хоёрдугаарт, хоёр сая нэг зуун мянган хүн асар уудам нутагт нэн таруу амьдарч сууна.

Гуравдугаарт, уудам цэлгэр нутаг дэвсгэр нь байгаль тэр чигээрээ байхаас бус хүний хараа хамгаалалтанд байна гэдэг бэрхтэй.

Дөрөвдүгээрт, мод суулгах, ой байгуулах ажил төдийлөн хийж ирээгүй тул амьдралын орчин ногоо зүлэг муутай.

Тавдугаарт, таван хошуу мал байгалийн шалгарлаар хэрхэн өссөнөөс тэр жилийн олз омгийг ихэвчлэн ярилцах учир мал аж ахуйгаа шинжлэх ухааны үндэстэйгээр хөгжүүлэх явдал хоцрогдонгүйг харуулна.

Зургадугаарт, эрт дээр үеэс нүүдэллэн амьдарч ирсэн уламжлалтай болохлоор таван хошуу малаа даган нүүдэллэж байх ёстой мэт бодоцгооно.

Долдугаарт, улс орныхоо газар нутгийг хөгжүүлэх төлөвлөгөө ч гэх юм уу орон зайн газар нутгийн нийгэм гэх зэрэг ойлголт бараг байхгүй шахам.

Наймдугаарт, хүн ам асар цөөхөнтэй Монгол улсын хувьд хүн амаа өсгөх асуудал туйлын чухал зорилт болно.

Есдүгээрт, ард иргэдийн нөөц хүчийг илрүүлэн ашиглахын тул нийгмийн хүмүүжлийн хөдөлгөөнийг өрнүүлэх ажил зүй ёсоор шаардагдаж байна.

Аравдугаарт, хамт олон тэргүүн эгнээнд явж зохион байгуулах ба тодорхой орон нутгийг шилж, тусгай загварыг баримтлан туршилтын журмаар ажлаа эхлэхийн сацуу нийгмийн хөгжлийн давалгаа түгэн дэлгэрэх боломжийг хангах ёстой болно.

Монголын хөдөөгийн нийгмийг хөгжүүлэх зорилтын тухай бүх салбар ойлгож түүний зорилт арга хэлбэрийг улс даяар хүн бүр мэдэж байхуйцаар нийгмийн хүмүүжлийн хөдөлгөөнийг өрнүүлнэ.

Энэ мэт монголын бодит байдалд монголын хөдөөгийн нийгмийг хөгжүүлэх асуудлуудыг цаашид хэрхэн шийдвэрлэх вэ? Шинэ тосгон хөдөлгөөний үндсэн зарчмуудын зохисыг үзэн харгалзвас ямар бол гэдэг асуудлыг дэвшүүлэн тавьж байна.

Монголын эрмэлзэх зорилго

Өмнө бүлэгт дурдсанчлан Монгол нь хүн ам цөөнтэй улсын хувьд тохиолдож оолох оёрхшээлийг хэрхэн даван туулах вэ гэдэг маш ээдрээтэй асуудал.

Нутаг дэвсгэртэйгээ харьцуулахад хүн ам хэт цөөн тул хот суурин байгуулах, хөрөнгө мөнгө хүн хүч дутах, үйлдвэрийн гадаадтай өрсөлдөх чадвар сул байна.

Монголд 1 ам дөрвөлжин км-т 1 хүн суудаг ба Канадад 2 хүн, Австралид 2 хүн, гэтэл дээрх хоёр улс тэргүүний орны тоонд ордог шүү дээ гэж зарим хүн марган хэлэлцэж болох юм. Гэтэл Канад 25 сая, Австрали 16 сая хүнтэй. Мөн тэдгээрийн хүн ам монголынхтой адил таруу биш нэг дор олноор бөөгнөрөн сууцгаадаг. Бас зарим нь Азид Монгол шиг цөөн хүнтэй улс бий шүү дээ хүн амын цөөнд санаа зоволтгүй гэх хүн ч гарч мэднэ. Жишээлбэл Израил 4 сая, Кувейт 1,5 сая, Сингапур 2,5 сая орчим хүнтэй боловч хөгжилтэй орнууд. Эдгээр улсын хүн ам цөөн авч дэвсгэр нутаг багатай учир бөөгнөрөл сайтан. Нэг үгээр хэлэхэд Канад Австрали нь сийрэг хүн амтайд тооцогдох боловч бөөгнөрөн суурьшсан хүн амдаа дулдуйдсан, Израил Кувейт Сингапур нь бага нутаг дээр тархан амьдардаг. Түүний гол шалтгаан бол нүүдэллэн амьдардагт оршино.

Улсуудын хоорондын өрсөлдөөн нь тухайн орны эрх ашгийн үүднээс үүсдэг тул Монгол нүүдэлчдийн орон гээд түүнийг тойрон гарахгүй нь лавтай.

Тиймээс монгол ч гэсэн нэгэнт шинэчлэл өөрчлөлтөд хаалга үүдээ нээсэн болохлоор ямар нэгэн аргаар өрсөлдөөний зам дээр гарч ирэх ёстой болно.

Түүнд хандивлах нэг зүйл бол манай улсын шинэ тосгон хөдөлгөөний туршлагад дулдуйдсан монгол маягийн хөдөөгийн нийгмийг хөгжүүлэх загвар болох «Гэр загварт хот»-ын төсөл юм.

Монголын бодит байдлыг харгалзан үзээд **эрмэлзэх зорилго**, гэвэл **нэгдүгээрт**, хүн хүчний өсөлтийн үндсийг бүрдүүлэх, **хоёрдугаарт**, хүн амаа олшруулах нөхцөлийг буй болгох явдал юм. Одоогийнхоо хүн хүчнийг баялаг болгохын тул нөөц хүнийг буй болгон нийгмийн хөгжилд тус болохуйц ашигт чанарыг дээшлүүлэх, нөгөө талаар, хүн амыг өсгөх зохист төслийг боловсруулснаар улс орныхоо хүчин чадлыг нэмэгдүүлэх хэрэгтэй. Хүн хүчний өсөлтийг хангахын тулд **ард иргэдийн ухамсрыг дээшлүүлэх** замаар нийгмийн шинэчлэлийг урагш ахиулах хүчин чадлыг олох хэрэгтэй. Хүн амаа өсгөхийн тул орон сууцны нөхцөлийг сайжруулж, **хүүхдийн үхэл эндэгдлийг эрс багасгах** шаардлагатай.

Монгол маягийн хөдөөгийн нийгмийг хөгжүүлэх хөдөлгөөнийг өрнүүлэх чиглэл

Монгол дахь хөдөөгийн нийгмийг хөгжүүлэх хөдөлгөөний **эцсийн зорилго бол улс орны хүчин чадлыг дээшлүүлэхэд оршино**. Монгол маягийн хөдөөгийн нийгмийг хөгжүүлэх хөдөлгөөнийг өрнүүлэх загварыг товчлон өгүүлбэл;

Нэгдүгээрт, хөдөөгийн нийгмийг хөгжүүлэх зорилтыг тодруулах ажил болно.

Хөдөөгийн нийгмийг хөгжүүлэх эцсийн зорилго улс орны хүчин чадлыг дээшлүүлэхэд орших тул цөөнөөр бодоход дараахи хоёр зүйлийг анхааралдаа авах хэрэгтэй. **Нэг нь** нутаг орны байдалд тохирсон хүмүүсийн ажиллах сонирхлыг татахуйц ажил өрнүүлж ард иргэдийн нөөц хүчийг илрүүлэн тодорхой зорилгод чиглүүлэх. **Нөгөө нэг нь** орон сууцны нөхцөлийг сайжруулах замаар хүн амын өсөлтийг дээшлүүлэх боломжийг өргөжүүлэх хэрэгтэй. Эл хоёр зүйлд дулдуйдан нэг талаар хөдөөгийнхний амьдралыг дээшлүүлэх нөгөө талаар хөдөө орон нутгийн хөрөнгө мөнгөний хувьд биеэ даасан байдлыг нь дээшлүүлэх явдал чухал. Тэгэж гэмээн хөдөө орон нутгийн эдийн засгийн хөгжлийн суурийг буй болгох боломжтой болох ба дагалдаад хөдөөгийн хот суурин байгуулагдан хөгжих сайхан нөхцөл бүрэлдэнэ.

Хоёрдугаарт, хөдөөгийн нийгмийг хөгжүүлэх хөдөлгөөнийг урагш ахиулах арга замын асуудал юм. Хөдөөгийн нийгмийг хөгжүүлэх хөдөлгөөн нь нэг удаагийн кампаничилсан байдлаар явагдаад ямар ч үр дүнд хүрэхгүй. **Хаа ч гэсэн ажил, үйл ажиллагаа зэрэгцэн** явагдах ёстой. Тухайлбал зорилгоо биелүүлэхийн тул **дээд зэргийн арга барил бүхий ажил үйлс зүй ёсоор дагалдана** гэсэн үг.

Дээд зэргийн арга барилыг сонгохын тул **голлон анхаарах зүйл** бол хийх гэж байгаа юм, түүний орон зай, цаг хугацааг зөв зохицуулах асуудал юм.

1. Орон зайн асуудал бол тухайн орон нутгийн бодит байдалд таарсан ажлыг юуны урьд сонгон хийхийн нэр.

2. Эздэд нь таацуулах асуудал гарна. Энэ нь тухайн газар оронд амьдарч байгаа хүмүүсийн нийтийн сонирхол юу болохыг сайтар олж түүнийг хэрэгжүүлэхийн тул нөөц хүч бололцоог илрүүлэн илүү үр бүтээлт аргыг зааж сургах явдал болно.

3. Хөдөөгийн нийгмийг хөгжүүлэх загвар нь манай улсын шинэ тосгон хөдөлгөөнийх л хамгийн үр дүнтэй гэж бодогдоно. Яагаад гэвэл шинэ тосгон хөдөлгөөн нь хувь хүмүүс өөрснөө сайтар ойлгож бүх хүчээ шавхан өөрийгөө хөгжүүлэн цаашлаад гэр бүл, ажлын газар, улмаар улс орныхоо хөгжил цэцэглэлтэд нэмэр хандиваа оруулна гэсэн үзэл бодлыг агуулж байдаг явдал юм.

Загварын гол бүрэлдэхүүнийг үзүүлбэл:

1. Тосгон бүр өөрснөө удирдах авьяас чадвар бүхий хүнээ сонгон тэднийг бөөгнөрүүлэн зохион байгуулалттай сургаж тосгоныхоо хөгжлийн төлөө амь биеэ үл хайрлах сэтгэлийг нь өөд татаж өгөх хэрэгтэй. Учир нь удирдагч хүн уул тосгоны гол цөм болох ёстой.

2. Тосгоны хөрөнгө мөнгө бол сохор зооц хэмнэж ихээхэн хуримтлалтай болох өчүүхэн бололцоог ч алдалгүй байж, **биеэ дааж хөгжих боломжийг хангана**. Тосгоны хөрөнгө мөнгийг хуримтлуулахын сацуу түүнийг хэрхэн зөв зарцуулах вэ гэдгээс болоод тосгоныхны хөдөлмөрлөх урам зоригийг сэргээх зэрэг олон зүйл шалтгаална.

3. Бодит ажлын үлгэр дуурнал гэдэг бол хүн бүрт багш болдог. Тийм утгаар, **хөдөлмөрөөрөө дэгжсэн тариачин ч** олон хүнд замыг нь зааж өгөх ба **онолын мэдлэгтэй хүн ч** олон хүний мэдлэгийн түвшинг өндөр шатанд гаргадаг гэдэг талаасаа мөн багш юм. Нийгэм хөгжихийн тул **бүх салбарт аливаа зүйлийг эзэмшиж болох боломжтой** гэдгийг хүн бүрийн цээжинд шингээж өгөх хэрэгтэй. Туршилтын бүс нутаг нь тэргүүний туршлагыг ашиглах явцдаа түүнийг цааш баяжуулдаг ач холбогдолтой.

Байгалиас голлон шалтгаалах үйлдвэрлэлд ажиллагчдын хувьд бол харзнах хандлага их байдаг. Тиймэрхүү хүмүүсийг өөрчлөн дагуулахын тул юуны өмнө бодит үлгэр үзүүлэхгүй бол болохгүй. Энэ утгаар, **үлгэр жишээ бүс нутгийг байгуулах шаардлагатай** болдог. Тэгвэл туршилтын бүс нутгийг чухам хаана байгуулваас зохимжтой вэ? Тэр нь олон зуун хүн саадгүй очиж үзэж болох газар байх шаардлагатай. Учир нь олныг өөрсдийнх нь нүдээр үзүүлэн сэнхрүүлэн итгүүлэх газар байх ёстой. Хот тосгон хоёрын уулзвар газар ч юм уу, нааш цааш зорчигч их хөлийн газар ч юм уу, алдар цуутай газар ч юм уу, Монгол өөрийн шаардлагатай гэж үзсэн нэг аймаг сумын нутгийг сайтар шилж сонгож олох хэрэгтэй.

5. Сайн сурлагатай хүүхдэд шагналт цалин нэмж өгч бусад оюутан нэрт дуурнал болгодгийн нэгэн адил, тэргүүний бүс нутгийг эн түрүүнд хөхүүлэн дэмжих нь үлгэр жишээ үзүүлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд ач холбогдолтой гэж үзнэ.

Хөдөөгийн нийгмийг хөгжүүлэх ерөнхий тохиолдолд, хоцрогдож яваа бүс нутгийг эн тэргүүнд дэмжих, ядуу хүмүүст юуны өмнө тусалдаг бол, манай улсын шинэ тосгон хөдөлгөөний хувьд тэгээгүй. **Хоцрогдмол орон нутгийг дэмжих, ядуу иргэдэд эхлэн туслах нь сүүл барих ба ядуу байвал туслаад байдаг юм** гэсэн муу зуршилтай болгоод зогсохгүй, тэргүүний хүмүүсийн урам зоригийг хугалж, хойшоо сууж доошоо малтахад хүргэх аюултай. Тиймээс тэргүүний тосгоныг юуны өмнө дэмжин тэтгэх нь бусдыг дагуулах чухал ач холбогдолтой.

Дээр өгүүлсэн зүйлс нь бүгд наад захын шаардлагат нөхцөлийг бүрдүүлэхээс хэтрэхгүй. Янз бүрийн бүс нутгийн онцлогт тохируулан алив асуудлыг шийдвэрлэн урагшлая гэвэл, **биеэ даасан үйл ажиллагаа, арга барилыг эрж хайхад чухал болно.**

Ухамсрыг дээшлүүлэх хийгээд хүнлэг чанарыг сайжруулах

Ухамсрыг дээшлүүлэх гэдэг бол ямарваа орны тохиолдолд илүү сайн нийгмийг байгуулахад байнгын хэрэгтэй зүйл гэдэг нь маргаангүй.

Монгол хүнд ч гэсэн, хөгжингүй нийгмийг байгуулахын тул ухамсрыг дээшлүүлэх асуудал гарч ирнэ. **Хүний ухамсар** гэдэг ганц талтай, нэгэн эсээс бүрдмэл зүйл биш, олон талтай олон эст зүйл. Түүнийг 4 хувааж үздэг. Үүнд;

Нэгдүгээрт, идэвхит ухамсар, **хоёрдугаарт**, аминч ухамсар, гуравдугаарт, хамтач ухамсар, **дөрөвдүгээрт**, үл хувирах ухамсар болно.

Идэвхит ба хамтач гэсэн нь эрмэлзэх, туслалцах агуулгатай бөгөөд хамт олны нэг гишүүн гэдгээ ухамсарласан, бусдын төлөө гэсэн бодолтой тул түүнийг газар сайгүй дэмжих шаардлагатай. Харин аминч ухамсар нь юуны түрүүнд хар амиа хоохойлсон санаа агуулагдах учир нийцэн зохиоход хэцүү, жожиг тасархай байдалтай. Үл хувирах ухамсар бол ертөнцийн бүх юм хувирч өөрчлөгдөх жамтан сөрөг тул хуучныг баримтламтгай, зөрүүд зантай нийлэхээрээ эв эеийг олоход бэрхшээлтэй. Нийгмийн нэг гишүүн байхаас аргагүй өнөөгийн нөхцөлд аминч ба үл хувирах ухамсраас үл салах нь зохимжгүй. Тиймээс түүнийг зайлшгүй өөрчлөх шаардлагатай.

Энэ мэтээс үзэхэд ухамсрыг дээшлүүлнэ гэдэг бол **хүн бүрийн онцлог байллыг харгалзана** гэсэн үг болж байна.

Тиймээс, нүднээ үл үзэгдэх ухамсар хэмээх энэ зүйлийг өөрчлөхдөө, нийгэм хэмээх тольд түсгэн харж, хувь хүний дутагдал юу болохыг хайж олж залруулах зам, арга барилыг сонгох хэрэгтэй болов. **Хүн өөрийн сайн ба саар талыг олж, саараа сайжруулах нь ухамсраа дээшлүүлэх хүч тэр мөн.** Энэ зам л чухамдаа хүн чанараа (хүний мөс) ши-

нэчлэн сайжруулах хамгийн дөт зам гэж хэлж болох юм. Хүн чанар (хүний мөс) ямар байгаагаас амьдралын хэм хэмжээ, цаашлаад нийгмийн хөгжлийн түвшин тодорхойлогдох тал буй.

Нийгмийг шинэчлэх хүмүүжил ба шинэ тосгон орчныг буй болгох нь

Нийгмийг өөрчлөх хүмүүжлийн хоёр талыг зэрэгцүүлэн авч явах хэрэгтэй болно. Яагаад гэвэл, **нийгмийн өөрчлөлт** гэдэг ойлголтонд хүмүүсийн нөөц хүчийг илрүүлэн нийгмийн хөгжилд зориулах асуудал, нөгөө талаар, хүмүүсийн амьдарч буй орчин ахуйг сайжруулах эл хоёр асуудлын алиныг ч орхигдуулалгүй зэрэг шийдвэрлэх шаардлагатай. **Нийгмийн хүмүүжилд** бол, үйл ажиллагаа явуулахад зохимжит газрыг олон талаас нь эрж олоход шаардлага бүхий газар нутгийн шинжилгээ судалгаа; хүний амьдрал ахуй орчиндоо хэрхэн зохицож буйн тухайд хүмүүшлиг газарзүйн хүмүүжил; тухайн нутагт ард түмэн ямаршуу хэв загвараар суурьшиж амьдарч ирсэн, цаашид хэрхэн хөгжих арга замын тухай хүмүүжил (боловсрол)-ийг бүхэлд нь хамаарна.

Орчин ахуйн хүмүүжилд юуны өмнө орон сууцны асуудлыг задлан шинжилж, бөөнөөр суурьших бүтцийг сайжруулахын зэрэгцээ, нийгмийн хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх боломжийг бүрдүүлэх асуудал хамаарагдана.

Ингэснээр, нэг талаар, амьдралын соёл дээшлэх боломжтой нөгөө талаар, амьдралын ахуй нөхцөлөө цаашид үргэлжлэн сайжруулах эрмэлзэлтэй болно. Үүнийг, ахуй орчныг буй болгон сайжруулах шинэ тосгон маягийн арга гэж үзвэл, Монголд энэхүү төслийг авч хэрэгжүүлэхээр чармайх нь улс нийгмээ хөгжүүлэхэд ашигтай гэж үзнэ.

Орон сууцат орчин ахуйг буй болгох хийгээд хүүхдийн эрүүл мэндийг сахин хамгаалах ажлын үр дүнг дээшлүүлэх нь

Орон сууцны орчин гэдэг бол хүний амьдралд шууд бөгөөд бодитойгоор нөлөөлдгийн хувьд анхаарахгүй байж огт болохгүй зүйлийн нэг. Ямар ч орны тохиолдолд, тухайн ард иргэдийн аж амьдралын түвшин нь тодорхой гэр бүлийн амьдралын түвшинд түшиглэдэг. **Гэр бүл** бол орон сууцны орчны үндсэн нэгж болохын дээр амьдралын эдийн засгийн хамгийн анхны байр юм.

Монгол хүний хөдөөгийн нийгмийн орон сууцны орчин нь гэр төвтэй байна. Гэрний сайн ба саар тал нь юу вэ гэдгийг баахан хатуувтар үнэлэн үзэхийн санхүү, улам сайжруулж болохгүй юу гэдгийг эрэгцүүлэн болвол яасан юм бэ.

Гэр бол нүүдлийн амьдралд тун тохиромжтой сайн талтай боловч жирэмсэн эмэгтэйн амьдралын орчин буюу нялх хүүхдийг өсгөх орчны хувьд таарамж муутай ч огт боломжгүй хэмээж хэрхэвч болохгүйг тэмдэглэхээс аргагүй. Хамгийн гол нь эх нялхсын эрүүл ахуйн орчин бөгөөд тэр нь нялх хүүхдийн амь нас тухайлбал хүүхдийн нас баралтын асуудалтай шулуун шугамаар холбогдоно. Хүүхэд төрмөгцөө онцгой орчинтой тулгарч болзошгүй тэр үед тун болгоомжлох хэрэгтэй байдаг. Хэвлий ба гадаад орчин эрс ялгаатай тул зохицож эс чадвал амьдрахад бэрх болсноор эндэж, тэр нь хүн амын өсөлтөнд нөлөөлнө.

Хүн амыг олшруулах арга нь хүүхэд олныг гаргахдаа бус, гарсан хүүхдийг эндэгдэлгүй 100 хувь бойжуулах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Хүүхэд олныг гаргая гэвэл ихэнх эмэгтэйчүүд дургүйцэх байх. Харин гаргасан хүүхдээ эндэгдэлгүй бойжуулцгаагаач гэвэл бүх эмэгтэйчүүд баярлах болно.

Бүх эмэгтэйчүүдийн хүсэн хүлээж баярлах зүйл бол гэрийн эрүүл ахуйг сайжруулж, төрөх нөхцөл ба хүүхэд бойжуулах ахуй болон аргыг сайжруулах явдал юм.

Үүнийг томоор хувааж өгүүлбэл, нэг нь төрөхийн өмнөх үеийн ахуй орчны асуудал, нөгөөх нь төрсний дараах үеийн орчин нөхцөлийн асуудал юм. Дээрх хоёр талыг жигд харгалзан үзэж орон сууцны ахуй байдлыг эрс өөд татаж чадваас тэр нь хүүхдийг өсгөн бойжуулахад их ач холбогдолтой байх болно.